



## THE WORLD OF THE LOTUS SUTRA

### Оройн Дээд Цагаан Лянхуа Судар

#### Амгалангаар суусны зүйл хэмээх 14-р бүлэг

Баясалцахын зүйл хэмээх 13-р бүлэгт бодисадва нар ирээдүйд саад бэрхшээл гарч ирэхийг таамаглаж, тэр үед ямар сэтгэлийн бэлтгэлтэй байхаа бурхан багшид хэлдэг. Үүний хариуд Шагжамүни будда “Үргэлж сэтгэлээ амгалан байлгаж, өөрийн хүслээр сургаал түгээгтүн” хэмээн айлдаж, үүний тулд ямар сэтгэлийн бэлтгэлтэй байх талаар нарийн зааж сургадаг.

Бодисадва нар сургаал айлдахад ямар ч саад бэрхшээл тулгарсан “Цагаан Лянхуа судрыг дэлгэрүүлэх болно” гэж тангараглахыг хараад туйлын ихэд биширсэн Манзушир бодисадва тэнд цугласан олныг төлөөлөн “Бурханы сургаал хэрэгжихээ байж, мартагдах дөхсөн цэвүүн цагт хэрхэн Цагаан Лянхуа судрыг айлдан түгээвэл зохих вэ” хэмээн Шагжамүни буддагаас асуув.

Шагжамүни будда өөрийн үйл хөдлөл болон бусадтай харилцах талаар биеийн амгалан үйл, хэл яриан ямар байвал зохих талаар хэлний амгалан үйл, бодол сэтгэл ямар байх талаар сэтгэлийн амгалан үйл, хүсэл мөрөөдөлдөө хүрэхийн тулд хэрхэн хичээх талаар тангарагын амгалан үйл гэсэн 4-н сэтгэлзүйн бэлтгэлийг айлдана.

Түүнчлэн Шагжамүни будда “Үсэнд зүүсэн чандмань эрдэнэ” хэмээх үлгэрийг ярьж, Цагаан Лянхуа судар ямар ховор гайхамшигтай сургаал болохыг айлддаг.

Нэгэн улсад Их хүчит Хүрдэн орчуулагч хэмээх хаан байв. Тэр хаан ард иргэдээ зовоох муу улсыг нэг нэгээр нь дарж, энх тайван болгов. Хаан дайнд гавьяа байгуулсан жанжинаа газар нутаг, алт эрдэнэсээр шагнасан боловч үсэндээ зүүсэн чандмань эрдэнэ хэнд өгөөгүй байна. Хэрэв тэр эрдэнэсээ өгөх юм бол эсрэгээр хүмүүс гайхан сэжиглэх болов уу хэмээн бодсон хэрэг. Гэхдээ маш их гавьяа зүтгэл гаргасан хүнд бол үсэндээ зүүсэн эрдэнэсээ өгнө гэжээ.

Бурхан багш Цагаан Лянхуа судрыг шавь нартаа тийм амархан айлдаагүй нь ч гэсэн үүнтэй адил юм. Бурхан багш бол сургаал хэмээх улсыг захирч буй хаан юм. энэ улсад янз бүрийн сэтгэлийн дайсан байсан хэдий ч бодисадва та нар түүнийг дарж чадлаа. Түүний шанд би та нарт амгалан сэтгэлийг өгсөн хэдий ч Цагаан Лянхуа судрыг бол айлдаагүй билээ. Гэвч бодисадва нар бурханы сургаалд эргэлзэхгүй болж, чанд хатуу итгэл үнэмшилтэй болох цагт Цагаан Лянхуа судрыг айлдмой. Энэхүү сургаал бол хүмүүст бурханы гэгээрлийг өгөх ариун нандин сургаал билээ. Энэ сургаалыг одоо л айлдах цаг нь болжээ” гээд Шагжамүни будда үлгэрээ дуусгадаг.

Эцэст нь 4-н амгалан үйлийг сахиснаар “ердийн амьдралд шаналал, зовлон гэж бодогдох зүйлс шаналал, зовлон биш болж хувирна. Энэ буяны ач нүүрэн дээр аяндаа тодорч, зан чанар, дүр төрх ч гайхамшигтай болно” хэмээн бурхан багш айлдаж энэ бүлэг төгсдөг.

Ингээд дараагийн бүлгээс “Үндсэн үүд” хэмээх хэсэг эхлэх ба энэ хэсэгт бурханы жинхэнэ дүр ямар болох нь тодорхой болдог.



**Бусдын өөрт байхгүй чанарыг хүндлэх нь**

Японы эртний уламжлалт сэтгэлгээнд аливаа зүйлийг үүсгэн бүтээдэг гайхамшигт нууц хүчийг “үүсгэн бүтээгч сүнс” гэсэн утгатай ханзаар бичиж “уялдаа холбоо” гэсэн ханзтай адил дуудлагаар уншдаг байв. Энэ нь бүх зүйлс уялдаа холбооны ачаар үүсэн бий болдог гэсэн утга бөгөөд японы энэхүү эртний уламжлалт сэтгэлгээ нь “бүх зүйлс уялдаа холбооны улмаас үүсдэг” гэсэн буддизмын үндсэн ухагдахуунтай нийцэж байгаа нь гайхалтай юм.

Хүн хоорондын харилцаа ч гэсэн ямар нөхцлөөр холбогдохоос шалтгаалан янз бүр байдаг. Тооны нэмэх ба үржүүлэх үйлдэлтэй адил зарим харилцаа нь бие биедээ нэмэх үр дагавартай байдаг бол зарим нь эсрэгээр хасах үйлдэлтэй адил нөлөө үзүүлдэг. Бид голцуу өөрт нэмэх эсвэл үржүүлэх нөлөө үзүүлэх харилцааг хүсэж, дээр нь аль болохоор зан ааш таарсан, өөрт тааламжтай хүнтэй харилцахыг хүсдэг.

Гэвч өөрт тааламжтай харилцаа гэдэг өөрийг заавал хөгжүүлнэ гэж хэлэхэд хэцүү. Жишээлбэл, байнга л хуучин танилуудтайгаа харилцаад байвал нэгэн хэвийн уйтгартай болж, яваандаа ярих сэдэв ч сонирхол ч байхгүй болж хөгжих дэвших зүйлгүй болж ирнэ.

Үржүүлэхийн хүрдтэй төстэй харилцаа бол эхнэр, нөхөр хоёрын харилцаа юм. Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн хамтдаа амьдарснаар шинэ амьдрал үүснэ. Ийм нөхцлөөр өөрөөсөө өөр хүнтэй холбогдсоноор илүү их хөгжиж, илүү ихийг бүтээдэг ба энэнд л амьдралын амт байдаг гэж хэлж болно.

Түүнчлэн нас, хүйс, эзэмшсэн мэргэжил, ажил нь өөр өөр байсан Үүсгэн Байгуулагч ба Мёоко багш нар эдгээр ялгааг давж, бие биенийхээ онцлог чанарыг өнгөлж хөгжүүлсэн нь тус нийгэмлэг үүсгэн



байгуулагдах нөхцөл болсон бөгөөд энэн нь өөрөөсөө тэс ондоо хүнтэй харилцах нь олон зүйлийг сургадаг болохыг гэрчилж байгаа болов уу.

Шагжамүни будда өөрийг нь алах гэж байсан Дэвадатыг “Мэргэн сургагч” хэмээн нэрлэж, магтсан нь хүн ямар ч юмнаас суралцаж болно гэдгийг сургасан билээ. Өөрөөр хэлбэл үүнийг бид өөрсдийнхөө амьдрал дээр аваад үзвэл ямагт бидэнд саад болж байдаг хүмүүсийг авч хаяна гэх биш харин ч уужим сэтгэлээр хүлээн зөвшөөрснөөр амьдралд илүү их боломж гарч ирнэ гэсэн үг юм. Ингэснээр эрх чөлөөтэй сайхан харилцааг үүсгэж чадах болов уу.

## Уужим сэтгэл

Өөрөөсөө эрс өөр хүнтэй харилцаж, бие биенийхээ онцлог чанарыг хөгжүүлж явахын тулд хэдэн чухал зүйлд анхаарах хэрэгтэй.

Нэгдүгээрт, өөрийгөө хүндлэх. Өөрийгөө хүндэлж чаддаггүй хүн бусдыг хүндэлж чадахгүй.

Хоёрдугаарт, үнэнч шулуун байх. Энэ нь ямар чухал болохыг яриад ч хэрэггүй биз. Жишээ нь, эхнэр нөхөр хоёрын хэрүүл маргааныг үнэнч, шулуун сэтгэл л зогсоож чадна гэдэгтээ та бүхэн санал нийлэх болов уу.

Гуравдугаарт, нөгөө хүнийхээ өөрт байхгүй зан аашыг хүлээн зөвшөөрөх. Эсрэг зан чанарыг нь хүлээн зөвшөөрч, хүндэлж, жижиг сажиг зөрчилд автагдахгүй байх чухал.

Хэрэв та нөгөө хүнийхээ эсрэг зан чанарыг хүлээн авч чадахгүй байгаа бол өөрийнхөө зорилго, хүсэл мөрөөдлөө дахин нэг эргэн хараад үзээрэй. Хүсэл мөрөөдөлдөө хамаг анхаарлаа хандуулж байсан цагт бусдын зан аашийг анзаарахаа ч болино. Харин ч эсрэгээр тэр өөрт байхгүй ондоо зан чанарыг өөрийгөө хөгжүүлэх тэжээл болгон өөрчилж чадаж ч магадгүй юм.

Ингэж аливаа харилцааг өөрийгөө хөгжүүлэх шит тэжээл болгон хүлээн авч чаддаг сэтгэлийн үндэс бол “тэнгэр газар нэгэн үндэстэй, бүх зүйлс нэгэн амьтай” гэсэн уужим сэтгэл юм. Ийм бодол сэтгэлээр хүнтэй харилцвал зохистой.

Уужим сэтгэлээр хүнтэй харилцаж дотноссоноор ямар ч харилцаа үржүүлэх хүрднээс ч илүү хязгааргүй их боломжийг нээнэ. Хичнээн хасах хариу гарах нь гарцаагүй гэж бодогдох харилцааг ч “дөрвөн далай нэгэн тэнгэр доор оршиж, бүх юмс нэгэн дарма дээр тогтдог” гэсэн уужим сэтгэлээр хүлээн авч чадвал тэр тааламжгүй хүн таны амьдралыг илүү баялаг болгож өгсөн нандин эрдэнэ болж хувирах юм.

“Косэй” 2012 оны 8 сарын дугаараас



# Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

Рисшо Косей Кай Нийгэмлэгийн Ирээдүйн Ерөнхийлөгч  
Нивано Коошо

## Өөрчлөгддөг ба өөрчлөгддөггүй зүйл

Өнөөдөр ч урьдын адил тэнгэр цэлмэж, улиралын цэцэг навчис жил бүр ямар байдаг яг л тэр янзаараа дэлгэрч байгаа ч, өнгөрсөн жилийн байгалийн гамшигаас хойш нийгэм эрс өөрчлөгдчихсэн мэт санагдана. Тэр үйл явдал бодит биш, зүүд байсан юм биш үү гэж ч бодогдох үе байна.

“Бүх зүйлс хувирч өөрчлөгддөг” гэж үргэлж л сурч байсан мөртлөө “өглөө сэргэл өчигдөрийн үргэжлэл өнөөдөр ирнэ” хэмээн юу ч өөрчлөгдөхгүй мэт боддог байв.

Гэтэл юун өчигдөрийн үргэжлэл байтугай хэн ч бодож төсөөлөөгүй байсан аймшигт нэгэн өдөр эхэлсэн билээ. Итгэхийн аргагүй, итгэхийг ч хүсэхгүй, зүүд байвал хурдхан сэргээр байна гэж бодсон ч бодит байдал гэдэг өөрчлөгдөхгүй. Өдийг хүртэл төлөвлөж байсан зүйл, төсөөлж байсан ирээдүй бүгд дахин хэзээ ч эргэж ирэхгүй гэдгийг ойлгосон.

Өөрийгөө ийм хүчгүй, сул дорой байсан гэдгээ мэдсэнээр “бусдын ач буянаар амьдарч байгаа” гэсэн амьдралын үндсэн ухагдахууныг марталгүй, одоо л жинхэнэ утгаараа шинэ амьдралыг эхлэж чадах мэт санагдана. Би юугаар ч тус болж чадахгүй гэдгээ мэдэж байсан ч та бүхэнтэй хүнд хэцүү үеийг хамт хуваалцаж, бие биенээ түшиж тулъя гэсэн бодлоор аль болох хурдан гамшигт нэрвэгдсэн газар луу явсан юм.

Айлын байшин, ажлын байр, усан онгоц, боомт гээд бүх л зүйл цунамигаар урсан алга болж, бөөн хог бөөгнөрч, тэдгээр хог нурмыг тусгай хувцас өмссөн ажилтнууд өглөөнөөс авхуулан цэвэрлэж байв. Өөрөө гэр оронгүй болчихсон байж, “надаас илүү хэцүү хүн бий” гээд ийш тийш хүнд туслан гүйх хүн, хорогдох байранд хоол хүнсээ хувааж идэх хүмүүс, сайн дураар туслах гэж цугларсан хүмүүс. Гэр бүл нь амьд эсэх нь мэдэгдэхгүй байхад гишүүдээ гадуур эрж хайх лидер гишүүд ч байв.

Маш хүчтэй байгалийн үзэгдлийн эсрэг хүний хүч чадал өчүүхэн гэдгийг мэдрэхийн хажуугаар эргэн сэргэн босъё хэмээн хичээх хүмүүсийн сэтгэлийн хүч тэнхээг ч өөрийн нүдээр харсан юм.



## Нивано Коошо

Рисшо Косей Кай нийгэмлэгийн ерөнхийлөгч Нивано Ничикогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуулч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараагаар тус нийгэмлэгийн удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн. Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа нийгэмлэгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагтай хамтран ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн тус нийгэмлэгийн дараагийн ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

Холын хол Токиод ч гэсэн өөрчлөлт гарч байв. Галт тэрэгний буудал, дэлгүүр, галт тэрэг гэрлээ цөөлсөн харагдана. Үүнд дургүйцэх хүн ч байхгүй, харин ч залуучууд хөгшин настай хүмүүст суудал тавьж өгөх нь элбэг харагдах болов. Урьд өмнө ичээд хийж зүрхэлдэггүй байсан бол одоо “гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн төлөө жоохон ч гэсэн тус нэмэрээ оруулъя” гэсэн сэтгэл хүмүүст эрч хүчийг өгч, хүмүүс өөрийн чадах зүйлээрээ хувь нэмрээ оруулж байна.

Нэг удаа гэрт сонин дуу чимээ сонсогдоод байхаар нь юу болсон юм бол гэтэл хүүхэд маань харанхуй жорлон дотор дуу дуулан сууж байсан юм.

“Гэрлээ асаагаач” гэтэл “Зүгээр зүгээр, гамшигт нэрвэгдсэн хүмүүс гэрлээ асаамаар байсан ч асааж чадахгүй байхад” гэж хэлсэн ба айхгүйн тулд чангаар дуу дуулж байсан байв.

Үүсгэн Байгуулагч “бодисадвагийн үйл бол хүний төлөө гэдэг боловч үнэндээ өөрийн төлөө байдаг юм” гэж хэлдэг байсан. Би үүнийг одоо л мэдэрч байна. Зөвхөн өөрийгөө л бодоод байвал гуниг айдсаар сэтгэл дүүрэх мэт санагдана. Харин бусдын төлөө санаа тавьж, тусалснаар өөрийгөө ч аварч, хүч чадлаа эргэн олж авч чадна.

Хүний сэтгэлийн гүнд байдаг нандин эрдэнэ ингэж гялалзаж байхыг би одоо л харж байна.

Япон орон, бидний сэтгэл санаа эргэн сэргэж, мандтал цаг хугацаа хэрэгтэй. Бид цаашдаа ч гэсэн Үүсгэн Байгуулагчаас уламжилан үлдсэн сайхан инээмсэглэлээр бие биенийхээ сэтгэлийг дэмжиж, зовлонгоо хуваалцаж, нэгэн сэтгэлээр энэ цаг үеийг хамтдаа туулцгаая.

## Уян хатан чанар ба талархах сэтгэл “Хулгайд алдсан машины ачаар”

Санфранциско салбар, хорооны ахлагч (шүнин)  
Танихана Чизүко

2011 оны 7 сарын 15-нд Санфранциско нийгэмлэгийн Урабон баярын ёслол дээр тавигдсан илтгэл

Би 2011 оны 5 сард Япон лидер гишүүдийн сургалтанд оролцохоор Лос-Анжелас явсан юм. Тэр өдрийн өглөө машин маань грашнаасаа хулгайд алдагдсан байв. Би энэ тухай нөхрөөсөө сонсоод “Худлаа байлгүй дээ. Бас л гадаа зогсоолд тавиад мартсан биз. Сайн хайвал олдох байлгүй” гэж бодов. Гэвч машин маань олдсонгүй. Тэр өдөр нөхөр маань Нагамото тэргүүнийг онгоцны буудал руу хүргэж өгөх ёстой байсан учир би шууд л тэргүүн рүү утсаар яриу. Тэргүүн энэ тухай сонсоод өөрийнхөө машинаар манайд ирсэн бөгөөд ингээд нөхөр маань өөрийнх нь машинаар тэргүүнийг онгоцны буудал руу хүргэж өгсөн юм.

Лос-Анжелас нийгэмлэг дээр болсон сургалтын дараа *хоза* хийсэн. Дүүргийн ахлагч (шибүчо) Кожима машин алдагдсан талаар *хоза* дээр сайн асуугаарай гэв. *Хоза* учирдагч нь сургалтын хэлтсийн ахлагч Кожима байв. Эхний өдрийн *хоза* дээр би өөрийгөө танилцуулж, машиныхаа талаар ч яриу. Би “дараа зөвөлгөө өгөөрэй” гэж хүссэн боловч *хоза* улирдагч юу ч хэлсэнгүй. Энэ тухайгаа

дүүргийн ахлагч Кожимад хэлтэл “Чи сайн хүсэлт тависан юм уу” гээд дараагийн удаа заавал зөвөлгөө аваарай гэв. Хоёр дахь өдрийн *хоза* дээр боловсролын хэлтсийн ахлагч “та, хулгайд алдсан машин бол минийх биш нөхрийн машин гээд өөрт хамаагүй бусдын хэрэг мэт бодож байгаа юм биш үү. Дээр нь энэ сургалтанд оролцсон нь Бурхан багш, тэргүүний энэрэнгүй сэтгэлийн ач гэдгийг ойлгоогүй байгаа бололтой. Тийм хүнд зөвөлгөө өгөх хүсэл надад алга. Тиймээс ч эхний өдрийн *хоза* дээр би юу ч хэлээгүй юм. Тэргүүнээс зөвөлгөө авсан нь дээр” гэж хэлэв.

Энэ талаар дүүргийн ахлагчид дахин хэлтэл “буцах онгоцондоо боломжийг харж байгаад тэргүүнээс сайн гуйж зөвөлгөө авбал яасан юм бэ” гэв.

Харих онгоцонд тэргүүний хажуугийн суудалд суув. Тэргүүнд энэ удаагийн болсон явдлын талаар хэлэв. Тэргүүн “Тийм үү, тийм юм болоо юу” хэмээн яриаг минь сонссон боловч тэрнээс өөр юм хэлэлгүй өнгөрөв. Тэгээд дараах долоо хоногийн *хоза* дээр ингэж хэлэв.

“Танихана, та уржинан жил жолооны үнэмлэх авсан мөртлөө огт жолоо барья ч гэхгүй, өөрөө юм хийе гэж ер бодохгүй юм аа. Иноүэ, Ли, хорооны ахлагч Брэннэр нар цаг гарган чамд жолоо барихыг зааж өгсөн байтал. Чи усан дээр суусан юм байна. Усан дээр суусан хүн өнгөн дээрээ гялалзсан, өөдрөг, хүн бүхэнтэй таарамжтай байдаг хэдий ч, цаана нь итгэхийн аргагүй их зан ч бас байдаг юм. Машин хулгайд алдсан гээд юу ч хийхгүй юм бол машин хэрэггүй л гэсэн үг. Энэ бол нөхөрт чинь ирсэн мессэж биш таньд ирсэн бурханы мессэж” гэж тэргүүн нилээн хатуухан хэлэв. Энэ үнэхээр үнэн.



Надад үнэхээр их зан байсан юм.

Бодоод үзэхээр 26 жилийн өмнө нөхөртэйгөө гэр бүл болж байхдаа ч “дуртайдаа гэрлээгүй” гэсэн бодол надад байсан. Нөхөр маань надад гэрлэх санал тавихад надад “хайртай” гэсэн мэдрэмж байгаагүй. Зүгээр л нөхөр маань Америкт амьдардаг болохоор, Вэстан онгоцны буудалд ажилладаг болохоор, жил бүр Япон руу явуулж байна гэж амласан болохоор, би өөрөө ч 37 хүрч байсан болохоор энэ л сүүлийн боломж гэж бодон гэрлэсэн юм. Япон руу жилд 1, 2 удаа бол заавал харина гэж бодож байсны дээр бүр ганц хоёр долоо хоногоор ч биш, сараас дээш хугацаагаар явж байв. Мөн гэрлэснээс хойш хадам аав ээжтэйгээ тийм ч таарамжтай биш байсан. Нөхөр маань ч намайг дэмжиж өмөөрдөг байсан болохоор хадам аав ээжтэй харилцах нь улам л ховордож ирсэн юм.

Ийнхүү би өөрийгөө мундаг, сайхан гэж бодон, талархах сэтгэл огт байхгүй байсан юм. Тийм л байх ёстой гэж бодож байсан. Энэ удаагийн машинаа алдсан хэргээр дамжуулж “надад талархах сэтгэл дутаж байсныг”, “өөрийнхөө ямар хувиа хичээсэн их зантай болохоо” мэдэж авлаа. Энэ бол тэргүүн болон дүүргийн ахлагчийн ач билээ. Ялангуяа Кожима дүүргийн ахлагч бол миний хувьд номон дээрээс л уншиж байсан Мёоко багш шиг хүн. Хатуу хэдий ч маш энэрэнгүй сэтгэлтэй хүн билээ.

Нөхөр маань “өнөөг хүртэл чам шиг хүний үг дуулдаггүй байсан хүн арай гэж үг дуулдаг боллоо” гэж хэлсэн. Мөн тэргүүн манай гэрт ном уншихаар ирэх үед нөхөр маань тэргүүнд ингэж хэлсэн гэсэн. “Эхнэр маань өөрчлөгдсөн. Би 26 жилийн турш эхнэрээ өөрчилж чадаагүй боловч таны ачаар өөрчлөгдлөө. Танд баярлалаа”.

Би үүнийг сонсоод тэргүүн, дүүргийн ахлагчаас зөвөлгөө авсан нь сайн болжээ гэж бодсон. Хүний өмнө намайг ганц ч удаа магтаж байгаагүй нөхөр маань ингэж их баярлах гэж. “Өөрөө өөрчлөгдвөл бусад

хүмүүс ч өөрчлөгдөнө” гэдэг үнэхээр үнэн юм байна. 26 жилийн турш нөхрөө өөрчилөх гэж хэрүүл уруул хийж охиныгоо ч их зовоосон байх.


Одоо нөхөр маань намайг нийгэмлэг явна гэхээр огт дургүйцэхгүй, бүр хүргэж өгч, ирж авдаг болсон. Гэртээ ном уншихад ч гэсэн хамт уншдаг болсон. Ингээд бодохоор надад талархах сэтгэл үнэхээр дутаж байж дээ гэж бодогдоно.

Энэ үйл явдлаар дамжуулж юу өөрчлөгдсөн бэ гээд бодоод үзвэл, хадам ээж бид хоёрын харилцаа өөрчлөгдсөн юм. Би нөхрийгөө хол амьдардаг ээж рүүгээ яваад ирье гэхэд нь “чи ганцаараа яваад ирэхгүй юу дэ” хэмээн дурамжхан хэлдэг байсан. Харин одоо бол “ээж дээрээ очиж байгаарай” гэж чин сэтгэлээсээ хэлж чаддаг болсон. Түүнчлэн гэртээ ном уншуулах үед хадам ээждээ “Улаан буурцагтай будаа агшаагаад ирээрэй” гэж чөлөөтэй хэлж гуйж чаддаг болсон. Бүр хадам ээждээ нөхрөөрөө хоол хүргүүлэх үе ч байх ба ээж үнэхээр их баярладаг. Нийгэмлэг рүү явна гэхэд ч их дэмждэг. Нөхөр маань “өөрийнхөө хийж байгаа зүйлд сэтгэл хангалуун байх гэдэг хамгийн сайхан зүйл” гэж хэлсэн. Өмнөх үетэй адил би нөхөрөө эсэргүүцэж маргалдахаа ч болисон.

Нийгэмлэг дээр янз бүрийн үйл ажиллагаанд оролцсоноор өөрийнхөө их зан, талархах сэтгэлгүй болохоо бага багаар мэдэрч байсан ч гэсэн энэ удаагийн машинаа хулгайд алдсан хэргээр дамжуулж өөрийгөө илүү эргэцүүлэн болож, өөрийгөө олж харж чадлаа. Цаашдаа ч тэргүүн болон дүүргийн ахлагч нараас салалгүй олон юмыг сурч мэдэж, улам уян хатан сэтгэлтэй болохын төлөө хичээх болно гэдгээ бурханы өмнө тангаргалаад илтгэлээ дуусгая. Баярлалаа.



## Бурхан багшийн жинхэнэ хүслийг биелүүлэхийг хичээх нь



Рисшо Косей Кай нийгэмлэгийн гишүүд бид бол бурханы шавь бөгөөд “Оройн дээд цагаан лянхуа судар” бидний гол судар юм. Түүнчлэн гол шүтээн нь Мөнхийн Будда юм.

Бурханы шавь хүний хувьд үүнээс илүү зүйл гэж юу байх билээ.

Бусдын хийснийг үл ойшоон, зөвхөн би хийж чадна гэж боддог хүмүүс байдаг. Гэвч буддизмд бурханы шавь гэдгээ ухамсарлан нэгэн сэтгэлээр өөрийн хийх ёстой зүйлдээ төвлөрөхийг сургадаг. Тэр нь Буддын ёс журмыг дагах, сайн үйлийг хийх, сэтгэлээ ариусгах хэмээх хүний амьдралд зайлшгүй байх хэрэгтэй зүйлсийг хийх явдал юм.

Үүнийг хийхэд өөрийгөө магтаж дөвийлгөх шаардлага байхгүй. Түүнчлэн бусад хүн миний хийснийг үнэлсэнгүй хэмээн гомдоллох шаардлага ч байхгүй юм. Мөргөлийн шүтээн, судар хоёр бүрдсэн байхад хамаг амьтныг энэрэх сэтгэлээр аливаа зүйлд хандахад хангалттай. Түүнээс ууланд бүгэж, бясалгал даян хийж, хүрхрээний усанд цохиулан суух зэрэг хүнд үйлүүдийг хийх шаардлагагүй юм.

Бурханы авралыг олж, аз жаргалтай амьдрахад ямар нэг онцгой нууц арга хэрэггүй. Бурханы шавь болсон бид нар бурхан багшийн хүслийг биелүүлэхийг хичээн, сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэх явдал чухал юм. Энэхүү ганц зүйлд анхаарлаа төвлөрүүлэхэд хангалттай гэж бодож байна.



## Сургаалын дагуу амьдрах баяр хөөр

Өнгөрсөн 7-р сард Сахалинд шинэ сүмийн нээлт, бурхан залах ёслол, Бангладешт лидерийн сургалт, Бангкокт 30 жилийн ойн баярын ёслол, Төв дээр дэлхийн лидер санга нарын сургалт болсон гээд олон чухал үйл явдал болсон билээ.

Лидерийн сургалтын сүүлийн өдөр сургалтанд оролцогчдийн төлөөлөл нар лекц болон нийгэмлэгийн дадлагаар сурч мэдсэн зүйлээсээ хуваалцсан. Тэдний сэтгэл хөдлөл, талархал, баяр хөөр, цаашдын зорилгыг сонсоод “сургаалыг суралцаж, хэрэгжүүлснээр хүний нүүр царай гэрэлтдэг болох”, “Косей-кай нийгэмлэгийн сургаал бурхан багшийн сургаалын үндэс болох”, “Косей-кай нийгэмлэгийн санга нар ахмад, багш нараасаа үлгэр дууриал авч, заасан сургаалынх нь дагуу амьдарч байгаа” болохыг өөрийн нүдээр харж, үнэхээр сайхан байсан.

Сургаалын дагуу амьдарснаар бидний царайд инээмсэглэл тодордог. Тиймээс өдөр бүр инээд хөөрөөр бялхсан амьдралыг өнгөрүүлцгээе. Түүнчлэн бурхан багшийн сургаалыг амьдралдаа хэрэгжүүлж амьдрахын сайхныг олон хүмүүст дамжуулугаая.



## Сахалин салбарын шинэ сүмийн нээлтийн ёслол

2012 оны 7 сарын 1-нд Сахалинд шинэ сүмийн нээлт, бурхан залах ёслолыг зохион байгуулав. Энэхүү ёслолын арга хэмжээнд нийгэмлэгийн ирээдүйн ерөнхийлөгч Коошо уригдан оролцсон юм.

1992 онд “Энх тайвны сургалт” зохион байгуулагдахад тухайн үед Саппоро нийгэмлэгийн тэргүүний үүргийг гүйцэтгэж байсан Сакай Норио (одоо нийгэмлэгийн зөвлөхөөр ажилладаг) Хоккайдогийн их сургуулийн 20-н оюутныг дагуулан Сахалин уруу усан онгоцоор явсан байна. Энэхүү учралаар Нагано Миса асан (одоогийн Сахалин дахь салбарын Бокү Айко шүнийн ээж) хамгийн анх Косей Кайн гишүүн болж элсэн орсон юм.

Түүнээс хойш 20 жилийн хугацаанд Хоккайдо дахь салбар сүмүүдийн гишүүдийн халуун дулаан тус дэмжлэгийн ачаар Сахалинд бурханы сургаал дэлгэрч, өнөөдрийн энэхүү билэгт өдрийг угтжээ. Бурхан залах ёслолын үйл ажиллагаанд Сахалины 70 орчим гишүүд, Японы зүүн хэсгийн салбарыг хариуцагч Имаигийн удирдлага дор байдаг Хоккайдогийн салбар сүмүүдийн төлөөлөгч нараас бүрдсэн 27 хүн, нийтдээ 100 гаруй хүн оролцсон байна.

Нийгэмлэгийн дараагийн ерөнхийлөгчөөр сонгогдоод буй Коошо нь ёслолын үйл ажиллагааг эхлүүлэн бурхан багшийг халхалсан хөшгийг нээсэн юм. Олны өмнө бурхан багшийн дүр ил гарахад сэтгэл нь хөдөлсөн гишүүд нижгэнэсэн алга ташилтаар баяр хөөрөө илэрхийлэв. Сахалины гишүүдийг төлөөлөн Бокү шүнийн илтгэл тавьсан юм. Тэрээр илтгэлдээ хойшид олон

хүнийг аз жаргалын замд хөтлөхийн тулд гэгээлэг, эелдэг, халуун дулаан хүн болохыг бурханы өмнө тангаргалав.

Ирээдүйн ерөнхийлөгч Коошо Сүмд бурхан залах үйл ажиллагаанд оролцож байгаа нь анх удаа юм. Тэрээр ёслолын үйл ажиллагаанд дээр хэлсэн үгэндээ “зовлон бэрхшээлтэй учрах үедээ сэтгэлээ бага ч болов засаж, энэхүү залсан бурхан багштай адил халуун дулаан сэтгэлээр өөрчилж үзэх. Тэрхүү халуун дулаан сэтгэл бол хэн ч булаан авч чадахгүй жинхэнэ эрдэнэ юм” хэмээн дурдав.

Энэхүү бурхан нь Орос улсад залагдаж буй анхны бурхан бөгөөд олон хүн энэхүү салбарт цугларч, бурханы сургаалыг даган аз жаргалтай болохыг хүсэн ерөөе.




Ирээдүйн ерөнхийлөгч Коошо Сахалин салбарын шинэ сүмийн нээлтийн ёслол дээр

### Рисшо Косей Кай байгууллагын тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон Хамтран үндэслэгч Наганума Мёоко нарын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Манай байгууллага нь “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ын сургаалыг гол номлолоо болгосон эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл бурхан багшийн сургаалыг гэр, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлэх замаар дэлхийн энх тайвныг бүтээн байгуулах гэсэн зорилготой хүмүүсийн нэгдэл юм.

Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикогийн удирдлага дор сургаал түгээх үйлсэд зүтгэж, шашны бусад байгууллага болон дэлхийн олон орны хүмүүстэй гар барин, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.



## SHAN-ZAI Volume 83 (August 2012)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс, Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, Japan 166-8537 TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail: shanzai@kosei-kai.or.jp  
Senior Editor: Rev. Shoko Mizutani Editor: Ms. Etsuko Nakamura Editorial Staff: Ms. Shiho Matsuoka, Ms. Yukino Kudo, Ms. Kaoru Saito, Ms. Mayumi Eto, Ms. Sayuri Suzuki, Ms. Eriko Kanao, Ms. Emi Makino, and Ms. Yurie Nogawa

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Португал, Тай, Монгол хэл дээр тогтмол хэвлэгдэн гарч байна. Зарим дугаар нь бусад орны хэл дээр хэвлэгдэх ториолдол байдаг.

※Санал хүсэлт, сэтгэгдэл байвал дээрх хаягаар холбоо барина уу.

※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын хэлтэстэй холбоо барина уу.

# Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

# 2012

## Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

## Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,  
CA 92612, U.S.A.  
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432  
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

## Branch under RKINA

### Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA  
Tel: (727) 560-2927  
e-mail: rktampabay@yahoo.com  
http://www.buddhismtampabay.org/

## Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang  
Bangkok 10310, Thailand  
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218  
e-mail: thairissho@csloxinfo.com

## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.  
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633  
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

### Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.  
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

### Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.  
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.  
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567  
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

### Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.  
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745  
e-mail: dharmasanantonio@gmail.com  
http://www.rkina.org/sanantonio.html

### Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

### Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

### Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

### Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.  
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437  
e-mail: rkksf@sbcglobal.net http://www.rkina.org/sanfrancisco.html

### Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.  
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261  
e-mail: rkseattle@juno.com

### Rissho Kosei-kai of Sacramento

### Rissho Kosei-kai of San Jose

### Rissho Kosei-kai of Vancouver

### Lotus Buddhist Circle

851 N. San Mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.  
http://www.buddhistlearningcenter.com/

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.  
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499  
e-mail: koseiny@aol.com http://rk-ny.org/

### Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.  
Tel & Fax: 1-847-394-0809  
e-mail: murakami4838@aol.com http://home.earthlink.net/~rkchi/

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.  
Tel & Fax: 1-405-943-5030  
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

### Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls  
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.  
Tel: 1-541-810-8127

### Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1571 Race Street, Denver, Colorado 80206, U.S.A.  
Tel: 1-303-810-3638

### Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.  
http://www.rkina-dayton.com/

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,  
CEP 04116-060, Brasil  
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304  
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

### Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,  
CEP 08730-000, Brasil  
Tel: 55-11-4724-8862

## Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjehng District, Taipei City 100  
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

### Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,  
Taichung City 401  
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

### Rissho Kosei-kai of Jilung

## Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701  
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

### Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,  
Pingtung County 900  
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

## Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea  
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696  
e-mail: krkk1125@hotmail.com

### Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,  
Republic of Korea  
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

### Korean Rissho Kosei-kai of Masan

## Branches under the Headquarters

### Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,  
North Point, Hong Kong,  
Special Administrative Region of the People's Republic of China  
*Tel:* 852-2-369-1836 *Fax:* 852-2-368-3730

### Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,  
Ulaanbaatar, Mongolia  
*Tel & Fax:* 976-11-318667  
*e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

### Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar,  
Mongolia

### Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk  
693005, Russian Federation  
*Tel & Fax:* 7-4242-77-05-14

### Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland  
*Tel:* 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053  
*e-mail:* rkkgva@wcc-coe.org

### Rissho Kosei-kai of the UK

### Rissho Kosei-kai of Venezia

Castello-2229 30122-Venezia Ve Italy  
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

### Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France  
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

### Rissho Kosei-kai of Sydney

## International Buddhist Congregation (IBC)

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel:* 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224  
*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

## Rissho Kosei-kai of South Asia Division

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel & Fax:* 880-31-2850238

### Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218  
*e-mail:* info.thairissho@gmail.com

### Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel & Fax:* 880-31-2850238

### Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,  
Dahka Cand.-1206, Bangladesh  
*Tel:* 880-2-8316887

### Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,  
Bangladesh

### Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

### Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

### Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

### Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

### Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,  
Bangladesh

### Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

### Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

## Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka  
*Tel:* 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

### Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,  
Sri Lanka

### Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

### Rissho Kosei-kai of Galle

No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

### Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

## Branches under the South Asia Division

### Delhi Dharma Center

B-117 (Basement Floors), Kalkaji,  
New Delhi-110019, India  
*Tel:* 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713  
*e-mail:* sakusena@hotmail.com

### Rissho Kosei-kai of West Delhi

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar  
New Delhi-110018, India

### Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,  
KOLKATA 700094, India

### Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,  
Kathmandu, Nepal  
*Tel:* 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832  
*e-mail:* nrkk@wlink.com.np

### Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

### Rissho Kosei-kai of Singapore

### Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,  
Phnom Penh, Cambodia

## Other Groups

### Rissho Kosei-kai Friends in Shanghai

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 Ou Yang Road,  
Shanghai 200081 China